



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар A/251

Сүхбаатар сум

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", 29.2. Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Монгол Улсад Зөгийн аж ахуй үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн арга хэмжээг 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрүүдэд Сүхбаатар суманд зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 4000000 /дөрвөн сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2019 оны 08 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Ц.Уранцэцэг/-т ирүүлэхийг Шаамар сумын Засаг дарга /М.Баярбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ